

НИЙТИЙН УДИРДЛАГА



ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ЗАСАГЛАЛ, ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ

*Н.Бурмаа**

***Abstract:** The first part of this paper focuses on directing theoretic thinking about local development, governance, state administration and civil servants into capacity development of civil servants and local development. The second part on introducing theories in practice by explaining capacity development of civil servants in aimags and local districts of Mongolia. Finally, the paper concludes by addressing some of the challenges Mongolian civil service currently facing.*

***Key words:** local comprehensive development partnership, local administrative reform, capacity development of the civil servants at local level.*

* * *

Орон нутагт мэдлэгтэй, мэргэшсэн, бүтээмж өндөртэй, төрийн албан хаагчдыг системтэйгээр бэлтгэх, сургах, иргэдтэйгээ эргэн холбогдох шүтэлцээтэй орон нутгийн төрийн албаны хүний нөөцийн бодлого ямар байх вэ гэдэг асуултаар өгүүллээ эхэлмээр байна. Мэдээж төрийн албан хаагчийн чадавхийг бэхжүүлэх асуудал төрийн захиргааны болон засаглалыг бүрэлдүүлэх төрийн институцийн болон ардчилсан чөлөөт сонгуулиар бүрэлдсэн төрийн тогтолцоотой нягт холбоотой. Хуулиар баталгаажсан тогтолцоогүйгээр аливаа засаглалын байгууллагын хууль эрхийн бүрэн эрх мэдэл хэрэгжих боломжгүй ба улмаар иргэдийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулах чадваргүй байх болно. Гэсэн хэдий ч ардчилсан сонголтоор бүрэлдсэн төрийн бүтэц засаглалын үйл ажиллагааг бодит байдалд байнга хариуцлагатай гүйцэтгэдэг гэсэн үг биш юм. Орон нутгийн төлөөллийн ардчиллын хувилбар нь засаг захиргаа нутаг дэвсгэр, орон нутгийн санхүү, төрийн захиргааны болон иргэдийн төлөөллийн оролцооны хувьд хялбар зохион байгуулагдах боломжтой мэт атлаа илүү түвэгтэй. Орон нутаг дахь бие даах эрх мэдэл нь үндэсний хэмжээний эрх ашиг, эн тэргүүний зорилгод заналхийлэх мөн үндэсний ардчилсан төрийн байгууламжид аюул учруулах эрсдэлтэй гэж үздэг. Иймд орон нутагт зөвхөн хязгаарлагдмал бие даасан байдал болон өөрийгөө удирдах эрхийг олгон үндэсний ЗГ гол шийдвэрүүдийг гаргадаг загвар бий. Энэ нөхцөлд орон нутгийн төлөөлөл тухайн орон нутгийн ашиг сонирхлыг зөвхөн хязгаарлагдмал түвшинд илэрхийлэх чадвартай ба түүнийхээ зохих хариуцлагыг хүлээнэ. Гэхдээ орон нутгийн төлөөллийн бие даасан байдал болон хариуцлагын хүрээ тухайн орон нутгийн иргэдийн эрх ашгийг илэрхийлэхэд хангалтгүй байх нөхцөл заримдаа үүсдэг. Энэ тохиолдолд тухайн орон нутгийн төлөөлөл орон нутгийн засаглалын үйл ажиллагааг хариуцлагатай явуулах чадваргүй болсноор орон нутгийн засаглалын асуудалд хүндрэл үүсэх магадлалтай. Иймд орон нутгийн

* МУИС, ОУХНУС-ийн Нийтийн Удирдлагын тэнхимийн эрхлэгч, профессор

өөрөө удирдах болон босоо тогтолцооны харилцан уялдаа засаглалын эрх мэдлийн хуваарилалтын хүрээ, хяналт ба хариуцлагын механизмыг нарийн тодорхой хуульчлах асуудал шийдвэрлэх хүчин зүйл бөгөөд орон нутгийн хариуцлагатай засаглалд анхаарах нь чухал байна.

Орон нутгийн хариуцлагатай засаглалын асуудлын хүрээнд:

1. Орон нутгийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт хариуцлагын хууль эрх зүйн оновчтой зохицуулалт
2. Орон нутгийн цогц хөгжил түншлэлийн асуудлуудыг дэлгэрэнгүй тайлбарлая.

Орон нутгийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт хариуцлагын хууль эрх зүйн оновчтой зохицуулалт чухал. Орон нутгийн удирдлагад эрх мэдлийг шилжүүлэх, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд сонгогдсон төлөөлөгчид иргэдээ сонсож тэдний ашиг сонирхлыг хэрхэн төлөөлж байгаа асуудал их ач холбогдолтой. Мэдээж тухайн улсын газар нутаг, хүн амын хэмжээ мөн тухайн улсын төрийн байгууламж, зохион байгуулалт, институцийн чадавхи, засаглалын үйл ажиллагааны онцлог зэрэг хүчин зүйл ихээхэн хэмжээгээр нөлөөлнө. Монгол Улс шиг үлэмж хэмжээний газар нутагтай, хүн амын тоо бага, нүүдэлчин соёл иргэншилтэй улс орны хувьд нутгийн өөрөө удирдах эрх бүхий улс орны хувьд үндэсний засаглалын дээд түвшинээс хамгийн доод түвшин хүртэл 5 хүртэл сонгуулиар бүрэлдсэн төлөөлөл байдаг ба тухайн төлөөлөл бүр өөрийн шийдвэр гаргах зохих эрх мэдэлтэй байгаа. Ийм системд орон нутгийн төлөөлөл бүхий этгээдэд тухайн нутгийг төлөөлөх, иргэдийн итгэл үнэмшлийг илэрхийлэх гол үүрэг ноогддог. Сонгогдсон төлөөлөлөгчидтэй иргэдийн холбоо маш ойр байдаг ба хувь хүнийг сонгох нь намын нэр дэвшигчийг сонгохоос илүү чухалд тооцогддог онцлогтой. Орон нутгийн шууд сонгогдсон төлөөлөл нь төрийн захиргаа болон хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын байр суурь, тухайлбал орон нутгийн захирагч эсвэл захиргааны даргын буюу хувь хүний нөлөөнөөс хамааралтай байна. Түүнчлэн орон нутгийн удирдлага иргэдээс шууд сонгогдсон уу эсвэл тухайн орон нутгийн төлөөллөөс сонгогдсон уу эсвэл ЗГ-аас томилогдсон уу, эсвэл тэрээр орон нутгийн удирдлагыг давхар хариуцан удирддаг уу эсвэл дээд байгууллагын удирдамжаар үйл ажиллагаа явуулдаг уу, эсвэл орон нутгийн төлөөллийг өөрөө удирддаг уу, эсвэл төлөөлөл нь орон нутгийн захирагчийн үйл ажиллагааг гаднаас хянадаг уу, төлөөллийн байгууллагад зөвхөн иргэдээс сонгогдсон төлөөлөгч нар ордог уу, эсвэл тус төлөөллийн байгууллагад захиргааны ажилтнууд тэгш эрхтэй оролцдог уу гэх асуудлууд маш нөлөөтэй. Монгол Улсын орон нутгийн түвшинд нийслэл, аймаг, сум дүүрэг, хороо багуудад дээрхи хувилбарууд холимог шинжтэй байгаа. Монгол Улсад Төрийн институц/байгууллагууд мэдлэг, судалгаа туршлагад суурилсан орон нутгийн мэргэжлийн байгууллага байх ёстой хэмээн үзэж ЗГ-тай холбоотой, ЗГ-аас томилогдсон, түүний үүрэг даалгавараас хамааралтай захирагч нэг талаас, нөгөө талаас тухайн нутаг дэвсгэрийн иргэдээс сонгогдсон төлөөллийн холбоог сонгодог загвар манай улсад үйлчилж байгаа. Тус загвар нь төвөөс хөгжлийг

удирдах, нөгөөтэйгүүр иргэдээс сонгогдсон төлөөллөөр дамжуулан хяналт тавих бололцоотой, тэнцвэртэй байдал бүрэлддэг хэмээн үздэг хэдий ч манай улсад хэрэгжүүлэгч субъектүүдийн намын харъяалал, мэдлэг боловсрол, хариуцлага, хяналтын зэрэг асуудлууд орон нутгийн төдийгүй үндэсний түвшинд доголдож байна. Магадгүй Монгол Улсад төлөөллийн бүтэц дээр суурилсан систем буюу орон нутгийн эрх ашгийг түлхүү тусгадаг, захирагчийн байр суурийг төлөөллийн байгууллагын шийдвэрээс хэт хамааралтай болгодог, орон нутгийн захиргааны ардчилсан хяналт өндөр хувилбар оновчтой байж болох талтай юм.

Орон нутгийн цогц хөгжил, түншлэлд орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн тогтвортой бөгөөд чанартай өсөлтийн асуудал чухлаар тавигдаж байна. Орон нутгийн хувьд байгалийн баялаг ихтэй аймгуудын хувьд засаглал, нийгэм эдийн засгийн хөгжлийн чанартай бөгөөд хүртээмжтэй өсөлт, нийгмийн хариуцлага, иргэдийн талаархи асуудлын талаар хөндөх бодолтой байна. Орон нутгийн хөгжлийн асуудалд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд ямар чиг үүрэгтэй байхаас гадна орон нутгийн түвшинд төрийн захиргааны байгууллагууд, уул уурхайн компаниуд, жижиг дунд бизнес эрхлэгчид төрийн бус байгууллагууд, иргэдийн хоорондын уялдаа холбоо хамтын ажиллагаа тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлүүд, ирээдүйн үр дүнгийн талаар авч үзье.

Байгалийн баялаг, ашигт малтмал ихтэй аймаг орон нутгийн хувьд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, иргэд, төрийн бус байгууллагууд, уул уурхайн компаниуд, жижиг дунд бизнес эрхлэгчид хамтран зөвшилцөн цогц түншлэлийн хүрээнд хамтран ажиллавал орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Учир нь тал бүрийн сонирхлын асуудалд хамтран хэлэлцэн шийдвэрлэх томоохон боломж бий болох бөгөөд хамгийн чухал асуудал бол хөгжлийн төлөөх хамтын харилцан ойлголцол, үр дүнтэй хамтын ажиллагаа юм. Энэхүү хамтарсан цогц хөгжил түншлэлийн хэлэлцлийн үр дүнд бий болсон орон нутгийн хөгжилд зайлшгүй шаардлагатай гол гогцоо асуудлыг тухайн орон нутгийн хөгжлийн урт хугацааны стратегийн төлөвлөлтөд баталснаар хүртээмжтэй, тогтвортой, чанартай өсөлтийг дэмжих бодлого хэрэгжих болно. Орон нутгийн цогц хөгжил түншлэлд иргэдийн оролцоо хамгийн чухал байр суурийг эзлэх бөгөөд нутгийн иргэдийн ядуурлыг бууруулсан, хариуцлагатай, үйл ажиллагааны өгөөж өндөртэй, иргэдийн хүсэлтийг ойлгон хүлээн авдаг ардчилсан төлөөллийн үүргийг бодит байдалд хэрэгжүүлэх үндсэн нөхцөл бүрэлдэх юм. Нөгөө талаас нутаг орны онцлогийг хамгийн сайн мэдэх, мэдлэгтэй иргэдийн мэдлэг боловсролыг орон нутгийн хөгжил, хөгжлийн бодлогод ашиглах боломж юм. Мөн иргэдийн оролцоог төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд татан оролцуулснаар иргэдийн зүгээс төрд итгэх итгэлийг бий болгох бэхжүүлэхэд чухал бөгөөд итгэл бол оролцоог илэрхийлдэг хүчин зүйл билээ. Үүний тулд иргэдийг арчилалд идэвхтэй суралцах, улмаар иргэдийг ардчилсан нийгмийн институцуудын хоорондын шүтэлцээ, холбоог ойлгон, өөрөө орон нутгийн төлөөлөлд оролцох сонирхолтой болох эсвэл иргэдийг төлөөлж буй төлөөлөгчдийг хянах чадвартай болгох үйл явц юм.

Олон нийтийн байгууллагууд нь тухайн нутаг дэвсгэрийн захиргааны

үйл ажиллагаа иргэдийн сонирхлыг хангалтгүй илэрхийлж байна гэж үзсэн нөхцөлд иргэдийн дуу хоолойг нийтэд ил тод сонсох үүрэгтэй. Олон нийтийн байгууллагууд ард иргэдийн хүсэл сонирхолд ойр байснаар иргэдэд тулгарч буй бэрхшээл, түүнийг хэрхэн шийдвэрлэх арга замын талаар олон нийтийн байгууллагууд мэргэшсэн байдаг. Олон нийтийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд нийгмийн өмнө тулгарч буй асуудлын талаархи талуудын оролцоо болон харилцан ойлголт сайжрах учиртай. Нөгөө талаас төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломж орон нутагт нээлттэй болсон. Олон нийтийн байгууллагуудтай хамтарснаар нийгмийн хамгийн ядуу, эмзэг хэсгийн дуу хоолойг сонсох онцгой боломж нээгддэг. Ингэснээр засаглалд болон орон нутгийн цогц хөгжилд олон нийтийг хамруулах стратеги биеллээ олж байгаа хэрэг юм.

Уул уурхайн компаниудын хувьд орон нутгийн цогц хөгжлийн түншлэлд оролцсоноор зөвхөн ашгийн төлөө ажиллах туйлын зорилго сонирхол нь орон нутгийн хөгжлийн зорилгод нийцсэнээр байгаль орчин, иргэддээ ээлтэй нийгмийн хариуцлагатай уул уурхайн хөгжлийг бий болгох үндсэн нөхцлийг бий болгохоос гадна иргэд, төрийн бус байгууллагууд, төрийн байгууллага, жижиг дунд бизнестэй хамтран хөгжих, тэднийг дэмжих, харилцан ойлголцох, асуудлаа хамтран шийдвэрлэх боломж бүрдэнэ. Уул уурхайн компаниудын хувьд тухайн орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, иргэдэд мэргэжлийн боловсрол олгох, залуучуудыг бүтээн байгуулалтад татан оролцуулах, орон нутгийн төсөвт шууд ба шууд бус бодит орлогыг бий болгох, орон нутгийн стратегийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулдаг хэдий ч нийгмийн хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлогыг орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, иргэд, төрийн бус байгууллагууд болон жижиг бизнесийн төлөөлөлтэй хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь Монгол Улсад бий болоод байгаа нөхцөл байдал батлан харуулж байна.

Жижиг дунд бизнес эрхлэгчдийн хувьд тухайн орон нутгийн онцлог, нөөц баялагт түшиглэсэн иргэдийн өдөр тутмын хэрэгцээг нарийн мэдэрсэн, зах зээлд уян хатан, хөрвөх чадвартай, эрсдэлд хялбар өртөмтгий шинжтэй байдаг. Орон нутгийн иргэдийг төрөл бүрийн нарийн мэргэжил шаардагдах болон мөн нарийн мэргэжлийн ур чадвар төдийлөн шаардахгүй ажлын байраар хангах, тэдний эрх ашгийг хамгаалах, орон нутгийн төсөвт орлого оруулахад тодорхой үүрэг гүйцэтгэдэг утгаараа орон нутгийн хөгжил болон цогц түншлэлийн үндсэн бүрэлдэхүүнд орно. Орон нутаг болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь *Public Private Partnership* буюу олон нийт, хувийн хэвшлийн түншлэлийн нэг хэсэг юм. Орон нутгийн төрийн байгууллага: энэхүү институцийн чадавхи сайн байснаар орон нутгийн цогц хөгжлийн стратегийн үндсэн чиглүүлэгч болдгийн хувьд эдгээр байгууллагуудад ажиллаж буй төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшил, бүтээмжийн асуудал чухал. Түүнчлэн төрийн байгууллага, орон нутгийн төлөөллийн хэлэлцэж буй асуудлын төсөл, шийдвэр нь нийтэд нээлттэй ил тод иргэдэд асууж лавлах боломж олгосон нээлттэй байх шаардлагатай. Орон

нутгийн ИХТ-ийн байгууллага нь нэг талаас иргэдээс сонгогдсон төлөөлөгчид ба иргэдийн бүлэглэл байдаг. Орон нутгийн төрийн захиргааны болон удирдах байгууллагуудын нутгийн өөрөө удирдах засаглалыг санхүүгийн бие даасан байдалтай хослуулсан бүтэц бүрдүүлэх, нөгөөтэйгүүр орон нутгийн удирдах болон захиргааны байгууллагуудын хоорондын ажлын уялдаа эрх мэдлийг тэнцвэртэй хуваарилах шаардлагатай. Өнөөдөр бид орон нутгийн төлөөллийн ардчилалын гол ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байгаа ч орон нутгийн төрийн институц/байгууламжийн шийдвэр гаргах хүрээг өргөжүүлэх нь онцгой ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрөх шаардлага үүсэж байна. Орон нутгийн захиргааны зүгээс засаглалын зөв менежмент явуулаагүй тохиолдолд хамтын ажиллагаа үр дүнгүй болох аюултайг судалгааны ажлууд нотолжээ. Юуны өмнө иргэний нийгмийн хөгжил буурай улсуудад өөрөө удирдах зарчмыг мөрдөх үйл явцад нийгмийн хамгийн эмзэг хэсгийн дуу хоолой сонсогдохгүй өнгөрч, тэнцвэргүй байдал үүсдэг байна.

Олон улсад хийсэн харьцуулсан судалгааг харахад орон нутгийн засаглал болон үйл ажиллагаанд хүчтэй үндэсний ЗГ-тай, сул дорой орон нутгийн засаг захиргаатай улс орнуудын туршлагаас Монгол Улс хуулбарлан хэрэгжүүлэх оролдлого хийж байгаа нь Монгол Улсын өөрийн онцлогийн асуудлыг орхигдуулдаг нь олонтаа ажиглагддаг. Ийнхүү бусад орнуудын туршлагыг хуулбарлах нь амар хялбар арга мэт боловч үндэсний онцлог, нэгдсэн бодлого, судлаачдын судалгааны үр дүнг сонсолгүй шийдвэр гаргадаг улс төрийн шийдвэр гаргагчдын зүгээс орон нутгийн хөгжилд чиглэсэн цогц асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа нь иж бүрэн стратеги боловсруулах шаардлагатай гэдэг нь нэгэнт тодорхой болсон.

Орон нутгийн цогц хөгжил-түншлэл стратегийг боловсруулахад тухайн үйл явцад оролцогч талууд-орон нутгийн удирдлага, иргэд, олон нийтийн байгууллагууд болон хувийн хэвшил-өөрсдийн тавьсан зорилго болон талуудын онцлогийг харгалзсан нэгдмэл ойлголттой болж нэгдэж ажиллах нь чухал. Орон нутгийн захиргаанаас бүх оролцогч талуудыг хамарсан удирдлагын баримтлал боловсруулсан ч оролцогч тус бүрийн зорилго, бүтээмжийн талаархи тэдний ойлголтыг харгалзаагүй нөхцөлд амжилтанд хүрэхгүй байгаа практик туршлага амьдралаас бид бэлхнээ харж байна.

Энэхүү хөндсөн хэсгийг нэгтгэн дүгнэвэл аймаг орон нутагт хамтын ажиллагаанд хэрэглэх арга хэрэгсэл нь талуудын эзэлж буй анхан шатны байр сууринаас хамаарна. Орон нутгийн цогц хөгжил-Хамтын ажиллагааны хүрээнд эдгээр талуудын төлөөллийн удаан хугацааны, байнгын мэдээлэл солилцоо, зөвлөлдөх уулзалтууд, төслүүд, тэднийг хэрэгжүүлэх стратеги хамтран боловсруулах, үр дүнг хамтран дүгнэн суралцах үйл ажиллагаанууд чухал гэдэг нь Монгол Улсын Увс, Өвөрхангай, Сэлэнгэ, Баянхонгор аймгуудад бидний зүгээс GIZ-н төсөл хөтөлбөр, эрдэмтдийн судалгаа шинжилгээний ажлуудын үр дүнгээр нотолж болохоор байна. Энэхүү олон талын хамтын үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортойгоор оролцогч талуудын тэгш оролцоог бий болгосноор амжилттай хэрэгжүүлж болох нааштай алхмууд амьдрал дээр бий болж байгааг дурьдахад

сэтгэл ханамжтай байна. Гэсэн хэдий ч Монгол Улсад улс төрийн сонгуулийн үр дүнд бий болж заншиж эхлээд байгаа “шинэ” засаглалын дур зоргоор авирладаг холч бус зөвхөн сонгуулийн бодлого, сонгуулийн амлалтыг биелүүлэх хэрэгсэл болгон ашиглах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор урт удаан хугацааны стратеги төлөвлөгөө болгон орон нутгийн бүхий л талын оролцооны шийдвэр болгон тууштай хэрэгжүүлэх асуудал нэн чухал гэдэг нь Монгол Улсад бий болоод буй улс төр, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал харуулж байна.

Дээр тайлбарлагдсан төлөөллийн талуудын хоорондын болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын харилцах уялдаа нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний амьдралын нөхцөлийг сайжруулахад ач холбогдолтой тул нийгмийн янз бүрийн төлөөллийн хувь нэмрийг хэрхэн нэгдмэл хэмжээнд хүргэх вэ гэдэг асуудал чухал. Нэг нэгээсээ үл хамааралтай нийтийн болон хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд оршин тогтнох нь эерэг үр дагавар авчрахаас илүүтэйгээр нэг нэгнийхээ үйл ажиллагааг саармагжуулж, бүр сөрөг үр нөлөө үзүүлэх магадлалтайг бас мартаж болохгүй.

Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын хоорондын уялдаа холбооны асуудал хамгаас чухлыг мартаж болохгүй. Хоёр болон түүнээс дээш тооны төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа нь нэгдсэн хүчний нөлөөний онолын үр ашигтай, үр нөлөөтэй, бүтээмжэй ажиллах зорилготой хүчээ нэгтгэх эсвэл тухайн нэгжийн чадавхи сул байгаатай уялдуулан илүү өндөр түвшинд гарах шаардлага үүссэн нөхцөлд эхэлдэг. Энэхүү хамтын ажиллагааг тухайн орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд эсвэл хэд хэдэн орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд хамтран ажиллах хувилбар бас бий. Тухайн орон нутгийн иргэдийн сайн сайхан амьдрал руу чиглүүлсэн улс төрийн чухал зорилтыг тодорхойлох мөн нийгмийн төлөөллийн талуудын ашиг сонирхлыг нэгтгэн, тухайн зорилгод хүрэхэд ашиглах эрх нь ардчилсан эрх зүйн хүрээнд бүрдсэн орон нутгийн төрийн засаг захиргааны байгууллагад байгаа. Орон нутгийн иргэдийн хувьд гагцхүү тухайн нутгийн төрийн институцууд/байгууламжууд хариуцлага хүлээдэг тул сайтар бодож боловсруулсан байх шаардлагатай нь ойлгомжтой. Үүнээс гадна орон нутгийн эрх мэдэлтнүүдийн өмнө тулгарч буй нэг асуудал нь тэдний өмнөө тавьсан зорилгодоо хүрэхэд өөрт байгаа нөөц бололцоо хязгаарлагдмал гэдгийг бас мартаж болохгүй.

“Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-ийн баримт бичгийн хүрээнд хүний нөөцтэй холбоотой доорх үзэл санаа уг баримт бичгийн 4.3-ын байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийн стратеги гэсэн хэсэгт: Төрийн байгууллагын дотоод шийдвэр нь ил тод, байх, ажлын гүйцэтгэлд чиглэсэн байх явдлыг хангасан дүрэм, журам, зааврыг боловсруулах, хүний нөөцийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, мөн төрийн албан хаагч бүрт хамгийн чухал шаардлагатай ур чадвар, тухайлбал төрийн албанд бүхэлд нь хамаарах

бодлогын дүн шинжилгээ хийх, эрсдлийн менежмент, мэдээллийн технологи ашиглах ба хүний нөөцийн удирдлага, түүнчлэн гүйцэтгэлийн удирдлагын ур чадвар эзэмшүүлэх тухай заасан байдаг. Монгол Улсад хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа нийт 4295 байгууллага, нийт 1836002 орчим төрийн албан хаагч ажиллаж 16 хүнд 1 төрийн албан хаагч ноогдож байна. Монгол Улсад 1996 оноос улс төрийн сонгуулийн үр дүнд төрийн жинхэнэ албан хаагчид даган солигддог асуудал хойш хэвшил болж эхэлсэн. 2012 оны сонгуулиас хойш Засгийн газрын бүтцэд хэдэн хэдэн удаа өөрчлөлт орсон бөгөөд энэ төрийн албаны тогтвортой, залгамж чанартай байх зарчим алдагдахад хүрч үйл ажиллагааны эрч хүч, үр ашиг буурсан үзүүлэлт гарсан. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны тайланд төрийн албаны хүний нөөцийн талаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан “Монгол төрийн залгамж чанар, төрийн удирдлагыг бэхжүүлэх” тухай дотоод аюулгүй байдлын үндэс сулрахад хүргэж болзошгүй байна хэмээн 2015 оны 3 сард Монгол УИХ-д тайлагнасан.

Судлаачдын гаргасан дүгнэлтээр төрийн албан хаагчдын 35.1 хувь нь тухайн албан тушаалдаа нэг жил хүртэл, 26.9 хувь нь 2-4 жилийн хугацаанд ажиллаж байна гэж дүгнэсэн нь төрийн албан хаагчийн 62 хувь нь тухайн албан тушаалд 4 хүртэл жил ажиллаж байгаа гэсэн үг юм. Дээр дурьдсан Увс, Баянхонгор, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудын төрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх талаар хийсэн судалгааны үр дүн болон хэрэгжүүлсэн төслийн 3 жилийн үр дүн дээрх дүгнэлтүүдийг баталж, Монгол Улсын төрийн албаны хүний нөөцийн менежментэд “Спойл тогтолцоо” үйлчилж байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Нэгэнт “Спойл тогтолцоо”-ны талаар яригдаж байгаа болохоор үр ашиг, үр дүн, үр нөлөө нь төрийн албан хаагчийн бүтээмжийг үнэлэх систем байхгүй, төр өөрөө хамгийн муу менежер гэдгээ харуулж байгаа хэрэг юм. Түүнчлэн төрийн албан хаагчдийн цалин хөлсний адил тэгш байдал мөн хувийн болон төрийн албан хаагчийн цалингийн зөрүү их байгаа нь төрийн байгууллагад чадварлаг ажилтныг ажиллуулахад хөшүүрэг болж чадахгүй байгаа төрийн сектороос хувийн секторт шилжин ажиллах тэр дундаа уул уурхайн салбарт ажиллах сонирхлыг нилээн бий болгож байна. Мөн төрийн албан хаагчийн бага цалин хөлс нь эрх мэдэлтэн болон хөрөнгө чинээтэй хүмүүст үйлчлэх нэг шалтгаан болж байгаа гэдэг нь тэдгээр албан тушаалтны гаргасан шийдвэр болон гарч байгаа хэрэг зөрчлөөс харагдаж байгаа юм.

Олон улсын жишгийг харахад зөвхөн төвлөрлийг бууруулснаар биш гагцхүү иргэдийн ашиг сонирхолд нийцсэн, тэдний зүгээс хяналт тавих боломж олгосон, иргэдээс сонгогдсон орон нутгийн засаглалд үндэслэлсэн өөрөө удирдах ёсыг бүрдүүлэх нь чухал гэдэг нь тодорхой байна. Иргэд, иргэний нийгэм, уул уурхай болон жижиг дунд бизнес эрхлэгчид, төрийн захиргааны байгууллагуудын харилцан ойлголцол, тэдний хамтын ажиллагаа нь нэгдсэн зорилгод хамтын хүчээ нэгтгэн бүх талын оролцоог хангаснаар орон нутгийн цогц хөгжилд жинтэй хувь

нэмэр оруулах юм. Энэхүү орон нутгийн хөгжил- цогц түншлэлд төрийн болон төрийн захиргааны байгууллага үндсэн менежерийн үүргийг гүйцэтгэн байнгын нээлттэй, ил тод яриа хэлэлцүүлэг явагдаж байх шаардлагатай. Энэ бүхнийг мэргэшсэн мэдлэгтэй төрийн албан хаагч удирдан жолоодох үүргийг оновчтой гүйцэтгэснээр иргэд орон нутгийн засаглалд итгэх итгэл аяндаа бий болсноор тогтвортой хөгжлийн үр дүнг орон нутаг, улс орон, иргэд хүртээмжтэй, чанартай хүртэх боломжтой болно гэдэгт эргэлзэхгүй байна